
БАТСҮХИЙН ЭНХБАТ

Партнер

“Эм-Ди-Эс энд ХаанЛекс” ХХН (“Хаанлекс Адвокэйтс” ХХН ба “Эм-Ди-Эс энд Ассошейтс” ХХН нарын нэгдлийн үр дүнд үүссэн)

Монгол Улс, Улаанбаатар хот
Утас: +976 9911-1061 (гар утас)
+976 (11) 330048 (оффис)
Факс: +976 (11) 330049
Имэйл хаяг: enkhbat@mdsa.mn



САЛБАР ЭРХЗҮЙ:

- Компанийн эрх зүй, Бизнесийн эрх зүй
- Төслийн санхүүжилт
- Эрчим хүч/Газрын тос

ГАДААД ХЭЛ:

- Орос хэл (сайн)
- Англи хэл (сайн)

МЭРГЭЖЛИЙН ТУРШЛАГА:

- Банк болон Санхүүгийн байгууллагууд
- Дэд бүтцийн төсөл
- Концесс/ТХХТ
- Хууль тогтоомжийн төсөл

БОЛОВСРОЛ:

- МУИС, Хууль зүйн сургууль, 1996
- Уэйк Форист Их Сургууль, Хууль зүйн сургууль (АНУ), 1999

Б.Энхбат нь Монгол Улсын эрх зүй болон бизнесийн салбарт 20 гаруй жил ажиллаж байгаа хуульчдын нэг. Тэрээр төрийн байгууллагад ч, хувийн хэвшлийн (бизнесын) салбарт ч ажиллаж байсан туршлагатай.

Түүний ажлын гараа нь ХЗЯ-ны Эрх зүйн бодлогын газарт бизнес, аж ахуйн хууль тогтоомжийн төсөл боловсруулах мэргэжилтнээс эхэлсэн. ХЗЯ-нд ажиллах хугацаандаа Монгол Улсын Иргэний хууль, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай, Дампуурлын тухай, Санхүүгийн түрээсийн болон татварын багц хуулийн төслүүдийг боловсруулахад оролцож байсан.

Б.Энхбат нь бизнесын салбарт буюу Ньюком групп, тус группын хоёр том охин компани болох Мобиком Корпораци (Хууль, Захиргаа, Хүний нөөц хариуцсан захирал) болон Изинис Эйрвэйз (Хууль, Коммерын асуудал эрхэлсэн захирал) зэрэг компаниудад удирдах албан тушаалд ажиллаж байсан. Эдгээр компаниудад ажиллах явцдаа тэрээр хууль эрх зүй болон төр засагтай харилцах харилцаа, бизнесын стратеги, хүний нөөцийн менежмент, компанийн санхүүжгийн удирдлагын чиглэлээр туршлагатай болсон.

Б.Энхбат нь томоохон төслүүд (дэд бүтцийн, эрчим хүчний, уул уурхайн г.м.) болон бизнес, компанийн хэлцэл дээр дагнан ажилладаг. Түүний үйлчлүүлэгчдэд төслийн зээлдүүлэгчид (олон улсын банкууд болон private зээлдүүлэгчид) ба төслийн спонсорууд багтдаг. Тухайлбал, Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (ЕСБХБ), Азийн Хөгжлийн Банк (АХБ) болон Хилийн Чанад дахь Хувийн Хөрөнгө Оруулалтын Корпорац (АНУ)-ийн Монгол дахь бизнес, хэлцэлд бүх талын эрх зүйн зөвлөгөөг өгдөг төдийгүй Монголын

дотоодын санхүүгийн байгууллага, гадаадын хөрөнгө оруулагч болон төсөл хэрэгжүүлэгч компаниудад зөвлөх үйлчилгээ үзүүлдэг.

Б.Энхбат нь 2014 оны 4 дүгээр сараас хойш “Эм-Ди-Эс энд ХаанЛекс” ХХН-ийн гишүүнээр (партнераар) ажиллаж байна.

АЖЛЫН ТУРШЛАГА

Хуулийн төсөл дээр ажилласан туршлага:

- *Иргэний хууль*
- *Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль*
- *Санхүүгийн түрээсийн тухай хууль*
- *Ашигт малтмалын тухай хууль*
- *Татварын хуулиуд*
- *Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой бусад хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль*
- *Үнэт Цаасны кастодианы журам.*

Ажиллаж байсан болон ажиллаж буй томоохон төсөл:

- *АХБ-наас Хаан Банкинд олгосон санхүүжилтын хэлцлийн хуулийн зөвлөх,*
- *Монгол Улсын хамгийн том ТХХТ болох Улаанбаатар хотын 5-р цахилгаан станцын төсөл болон түүний санхүүгийн гэрээнүүд дээр АХБ болон Монгол Улсын Засгийн Газрын хуулийн зөвлөх,*
- *ЕСБХБ, Хаан Банкны хооронд байгуулсан Эх Үүсвэргүй Батлан Даалтын хэлцлийн хуулийн зөвлөх,*
- *ЕСБХБ, Монполимет Группын хооронд цементайн үйлдвэр барих, ашиглалтад оруулах төслийн зээл, хувьцааны хөрөнгө оруулалтын санхүүжилтын хуулийн зөвлөх,*
- *ОРИС-ын Монгол Улс дахь KFC/Pizza Hut франчайзын санхүүжилтын төслийн хуулийн зөвлөх,*
- *GMP шаардлага хангасан анхны эмийн үйлдвэрийн хамтарсан компанийг байгуулах, хувьцаа гаргах төслийн хуулийн зөвлөх.*

---oOo---